

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2025 ОНЫ 05 ДУГААР САР ХҮРТЭЛХ
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

2025 оны 05 дугаар сарын 09

Улаанбаатар хот

Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Биелэлт	Хувь
	1	2	3	5
1.	"Дун өргөө" ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2025.01.27, дугаар 25/03	1.Нийслэлийн өмчит "Дун өргөө" ХХК-ийн 75 хувийг эзэмшигч "Хар дун" ХХК-тай хэлцэл хийж, тус компанийг орон нутгийн өмчид бүрэн (100 хувь) шилжүүлэн авах, энэ талаар шаардлагатай арга хэмжээг холбогдох хууль, журмын хүрээнд авч ажиллах эрхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д олгосугай.	Нийслэлийн Засаг даргын 2025.02.20-ны өдрийн А/266 дугаар захирамжаар Нийслэлийн өмчит "Дун өргөө" ХХК-ийн хувьцааг нийслэлийн өмчид шилжүүлэн авах асуудлаар хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулах холбогдох саналыг боловсруулан танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. НӨХГ-аас "Дун өргөө" ХХК-тай холбоотой материалын Ажлын хэсэгт танилцуулахаар бэлтгэсэн.	10%
2.	"Улаанбаатар смарт карт" ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2025.01.27, дугаар 25/13	1."Ти-мони" (Tmoney Co., Ltd) ХХК-ийн "Улаанбаатар смарт карт" ХХК-д эзэмшиж байсан 55 хувийн хувьцааг худалдан авсантай холбогдуулан нийслэлийн өмчийн бүртгэлд бүртгэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй. 2."Улаанбаатар смарт карт" ХХК-ийн 21 хувийн хувьцаа эзэмшигчидтэй хэлцэл хийж, хувьцааг худалдан авах, нийслэлийн өмчид бүрэн (100 хувь) шилжүүлэх ажлыг зохион байгуулах эрхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д олгосугай. 3."Улаанбаатар смарт карт" ХХК-ийн бусад хувьцааг худалдан авсантай холбогдуулан тус компанийн өмчийг нийслэлийн өмчид шилжүүлэн авах, бүртгүүлэх, компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг холбогдох хууль, журмын хүрээнд батлуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д олгосугай.	Нийслэлийн Засаг даргын 2025.03.12-ны өдрийн А/307 дугаар захирамжаар "Улаанбаатар смарт карт" ХХК-ийн хувьцаа эзэмшигч Бүгд Найрамдах Солонгос Улсын "Ти мони" ХК-ийн нийслэлд шилжүүлэх 55 хувийн хувьцаанд ногдох биет болон биет бус хөрөнгийг хүлээн авах Ажлын хэсгийн баталсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр эхний удаа хуралдаж биет болон биет бус хөрөнгө хүлээн авч, тоолох 2 дэд ажлын хэсэг байгуулахаар шийдвэрлэсэн. Биет хөрөнгө: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах даргаар ахлуулсан биет хөрөнгө тооло, хүлээлцэх дэд ажлын хэсэг 2025.04.17-04.23-ны өдрүүдэд Сити товер барилгын 4 давхарт байрлах "Улаанбаатар смарт карт" ХХК-ний төв байр биет хөрөнгө буюу 33.0 сая төгрөгийн үлдэх өртөгтэй тавилга эд хогшил, 93.5 сая төгрөгийн үлдэх өртөгтэй цахилгаан тоног төхөөрөмж, 67.6 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 5 тээврийн хэрэгсэл, 5.0 сая төгрөгийн 2 контейнер, бүртгэлгүй 26 сая төгрөгийн Ти мони ХК-аам ирүүлсэн 26.2 сая төгрөгийн хөрөнгийг тоолж, тухай бүр лац	100%

			нааж баталгаажуулан хүлээлгэн өгөхөд бэлэн болгосон. Тооллогын актад ажлын хэсгийн гишүүдээр гарын үзэг зуруулан баталагаажуулах ажил дууссан. Биет бус хөрөнгө: Биет бус хөрөнгийг хүлээлцэх ажлын хэсгийн даргаар НЗДТГ-ын Мэдээлэл технологийн газрын дарга П.Нэргүй ахлан ажиллаж байна. Тус хөрөнгийг хэрхэн хүлээн авах талар ажлын хэсгийн 2 дахь хурал 2025 оны 04 дүгээр сарын 23-ний өдөр хуралдаж сорс код, серверийн тоног төхөөрөмжийг тоолж, хүлээлцэх төлөвлөгөөний хуваарьт өөрчлөлт оруулсан. Биет бус хөрөнгийг хүлээн авахад БНСУ-ын хөгжүүлэгч байгууллагаас инженерүүдийг байлцуулан хүлээн авах санал гарсны дагуу системийн 1 инженер ирж программ хангамжийг үе шаттай хүлээлцэх ажлыг эхлүүлсэн. Мөнх серверийн өрөөнд байрлах хөрөнгийг 2025 оны 05 дугаар сарын 15-ны дотор хүлээлцэж дуусахаар ажиллаж байна.	
3.	Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулж, дүрэм батлах тухай 2025.02.26, дугаар 25/26	1.Нийслэлийн иргэдэд соёл урлагийн үйлчилгээ үзүүлэх, нийслэлийн өмчийн барилга, байгууламж, эд хөрөнгийн ашиглалт, үйлчилгээг хариуцах чиг үүрэг бүхий "Нийслэлийн соёлын төв өргөө" төсөвт үйлдвэрийн газрыг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулж, дүрмийг хавсралтаар шинэчлэн баталсугай. 2.Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулсантай холбоотойгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай: 2.1.баталсан дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлэх; 2.2.тус газрын бүтэц, орон тоог батлах.	НӨХГ-ын 2025.04.30-ны өдрийн 1/691 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас захирамжийн төсөлд саналын хуудас авхаар албан бичиг илгээж санал авч байна.	70%
4.	Барилга, байгууламж балансаас баланст шилжүүлэх тухай 2025.02.26, дугаар 25/27	1."Улаанбаатар хотын хөгжлийн корпораци" ХК-ийн баланст бүртгэлтэй, Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороонд байрлалтай, нийт 10,278 м2 талбай бүхий "Нийслэлийн соёлын төв өргөө А, Б корпус" нэрээр нэрлэгдсэн, хавсралтад дурдсан нийт 8,175,430,745 (найман тэрбум нэг зуун далан таван сая дөрвөн зуун гучин мянга долоон зуун дөчин тав) төгрөгийн үнэлгээтэй барилга байгууламж болон нийслэлийн Өмчийн харилцааны газрын баланст бүртгэлтэй, нийт 3830 м2 талбай бүхий "Нийслэлийн соёлын төв өргөө Г корпус" нэрээр нэрлэгдсэн, хавсралтад дурдсан нийт 9,548,536,450 (есөн тэрбум таван зуун дөчин найман сая таван зуун гучин зургаан мянга дөрвөн зуун тавь) төгрөгийн үнэлгээтэй барилга байгууламжийг "Нийслэлийн Соёлын төв өргөө" ОНӨААТҮГ-ын баланст тус тус шилжүүлсүгэй. 2.Барилга, байгууламжийг шилжүүлэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг	НӨХГ-ын 2025.04.30-ны өдрийн 1/691 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас захирамжийн төсөлд саналын хуудас авхаар албан бичиг илгээж санал авч байна.	70%

		Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.		
5.	Удирдах зөвлөл, Төлөөлөн удирдах Зөвлөлийн гишүүд болон хараат бус гишүүдийг томилох тухай 2025.02.26, дугаар 25/33	1.Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Удирдах зөвлөл, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон хараат бус гишүүдийг томилж, нэрсийг хавсралтаар баталсугай. 2.Компанийн тухай хууль, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан "Удирдах зөвлөлийн ажиллах журам", "Нийслэлийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам" болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөн ажиллахыг томилогдсон гишүүдэд даалгасугай.	НИТХ-ын Удирдах зөвлөл, ТУЗ-ын тогтоол, шийдвэрийн ТУЗ-н хараат бус гишүүдийг шинээр томилох гишүүдийн урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. ТУЗ-ын болон Удирдах зөвлөлийн тогтоол, шийдвэрийг НӨХГ-ын Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах тухай 1/450, 1/442, 1/443 1/444 1/445 1/446 1/447 1/448 тоот албан бичгээр ОНӨААТҮГ-т болон ХХК, ХК-д хүргүүлсэн.	100%
6.	Барилга байгууламж акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай 2025.02.26, дугаар 25/35	1.Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах нийт 40,860,300.00 (дөчин сая найман зуун жаран мянга гурван зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад дурдсан "Сувилал, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны төв"-ийн барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.	Нийслэлийн Засаг даргын 2025.04.01-ний өдрийн А/483 дугаар захирамжаар хуучин барилгыг акталж дансаас хассан.	100%
7.	"КОП 17 хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын газар" ОНӨААТҮГ байгуулах тухай 2025.04.15 25/60	1.Нийслэл Улаанбаатар хотод 2026 онд зохион байгуулагдах "Цөлжилттэй тэмцэх Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын Талуудын арван долоодугаар Бага хурал (COP-17)-ын барилга, байгууламжийг улсын болон орон нутгийн төсөв, бусад хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр эхлүүлэх, хугацаанд нь ашиглалтанд оруулах, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх чиг үүрэг бүхий "КОП 17 хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын газар" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулж, дүрмийг хавсралтаар баталсугай. 2."КОП 17 хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын газар" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулсантай холбоотойгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай: 2.1.баталсан дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлэх;	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2025.04.17-ны өдрийн 01/2397 дугаартай албан тоотоор БОУАӨ-ийн сайд С.Одонтуяад хандсан "Нэр ирүүлэх тухай" бичгийн хариуд БОУАӨ-ийн сайдын 2025.04.21-ний өдрийн 01/1907 албаг бичгээр тус газрын дүрэмд заасны дагуу захирлаар Б.Баттулгыг нэр дэвшүүлсэн хариу ирсэн. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн Б/78 дугаартай захирамжаар Б.Баттулгыг захирлаар томилсон. Баталсан дүрмийг, холбогдох бичиг баримтын хамт улсын бүртгэлд бүртгүүлж, 2025.05.12-ны өдөр 7154769 регистрийн дугаартай, 9014001153 хувийн хэргийн дугаартай хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ олгогдсон.	100%

		2.2.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамтай зөвшилцөн тус газрын бүтэц, орон тоог батлах;	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/682 дугаартай захирамжаар тус газрын зохион байгуулалтын бүтцийн бүдүүвч, бүтэц, орон тооны хязгаарыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025.05.13-ны өдрийн 01/2399 албан бичгээр хариу авч, зөвшилцөн баталсан.	
8.	Барилга байгууламж акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай 2025.02.26, дугаар 25/36	1.Чингэлтэй дүүргийн төсвийн хөрөнгөөр шинээр баригдаж буй хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн цогцолбор барилгын авто зогсоол бий болгохтой холбогдуулан тус дүүргийн 17 дугаар хороонд байрлах, нийт 25,752,230.00 (хорин таван сая долоон зуун тавин хоёр мянга хоёр зуун гуч) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 20,136,579.20 (хорин сая нэг зуун гучин зургаан мянга таван зуун далан есөн төгрөг хорин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 5,615,650.80 (таван сая зургаан зуун арван таван мянга зургаан зуун тавин төгрөг наян мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий хавсралтад дурдсан Өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.	НӨХГ-ын 2025.03.24-ны өдрийн 1/496 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас захирамжийн төсөлд саналын хуудас авхаар албан бичиг илгээж санал авч байна.	70%
9.	Барилга байгууламж балансаас баланст шилжүүлэх тухай 2025.02.26, дугаар 25/40	1."Нийслэлийн орон сууцны корпораци" ХК-ийн баланст бүртгэлтэй нийт, 21,731,708,631.85 (хорин нэгэн тэрбум долоон зуун гучин нэгэн сая долоон зуун найман мянга зургаан зуун гучин нэгэн төгрөг наян таван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, нийт 21,653,308,848.95 (хорин нэгэн тэрбум зургаан зуун тавин гурван сая гурван зуун найман мянга найман зуун дөчин найман төгрөг ерэн таван мөнгө) төгрөгийн үлдэх өртөг бүхий барилга байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгийг хавсралтын дагуу "Улаанбаатар орон сууцжуулалт" ХХК-д балансаас баланст шилжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй. 2.Энэ тогтоолын 1-т заасан хөрөнгийн эх үүсвэрийн хамт өр төлбөр, авлага, барьцаа хөрөнгийг тогтоол гарсан өдрөөр тасалбар болгож, тооцоо нийлсэн актаар баталгаажуулан "Улаанбаатар орон сууцжуулалт" ХХК-д балансаас баланст шилжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.	Нийслэлийн Засаг даргын 2025.03.31-ний өдрийн А/392 дугаар захирамжаар балансаас балансад шилжүүлсэн.	100%

10.	Удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх тухай 2025.04.15, дугаар 25/62	1.Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Удирдах зөвлөлийн гишүүнээс дор дурдсан нэр бүхий гишүүдийг чөлөөлсүгэй. 1.1."Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ-ын Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнээс Нийслэлийн ИТХ-ын Төлөөлөгч Ж.Сандагсүрэнг; 1.2."Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар" ОНӨААТҮГ-ын Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнээс Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Амгаланг;	НИТХ-ын Удирдах зөвлөл, ТУЗ-ын тогтоол, шийдвэрийн ТУЗ-н гишүүдийг чөлөөлж, шинээр томилох гишүүдийн урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. ТУЗ-ын болон Удирдах зөвлөлийн тогтоол, шийдвэрийг НӨХГ-ын Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах тухай 01/483, 1/484 тоот албан бичгээр ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ХОЁР ОНӨААТҮГ-т болон ХЭСЭГЧИЛСЭН ИНЖЕНЕРИЙН ХАНГАМЖИЙН УДИРДАХ ГАЗАР ОНӨААТҮГТ хүргүүлсэн.	100%
11.	Нийслэлийн өмчид 5 сургуулийн барилга байгууламж бүртгэн авах тухай 2025.04.15, дугаар 25/63	1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянзүрх, Налайх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж, ашиглалтад орсон нийт 43,870,943,551.00 (дөчин гурван тэрбум найман зуун далан сая есөн зуун дөчин гурван мянга таван зуун тавин нэг) төгрөгийн үнэ бүхий 5 сургуулийн барилга байгууламжийг хавсралтад дурдсаны дагуу нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.	НӨХГ-ын 2025.04.30-ны өдрийн 1/696 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас захирамжийн төсөлд саналын хуудас авхаар албан бичиг илгээж санал авч байна.	70%
12.	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга, байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авах тухай 2025.04.15, дугаар 25/64	1.Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан нийт 3,371,134,431.00 (гурван тэрбум гурван зуун далан нэгэн сая нэг зуун гучин дөрвөн мянга дөрвөн зуун гучин нэг) төгрөгийн өртөг бүхий 180 сурагчийн суудалтай бага сургууль, 120 ортой цэцэрлэгийн цогцолбор барилга, байгууламжийг хавсралтад дурдсаны дагуу нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.	НӨХГ-ын 2025.04.30-ны өдрийн 1/693 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас захирамжийн төсөлд саналын хуудас авхаар албан бичиг илгээж санал авч байна.	70%
13.	Нийслэлийн өмчид 8 цэцэрлэгийн барилга, байгууламжийг бүртгэн авах тухай 2025.04.15, дугаар 25/65	1.Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт тус тус баригдаж, ашиглалтад орсон нийт 28,572,029,258.00 (хорин найман тэрбум таван зуун далан хоёр сая хорин есөн мянга хоёр зуун тавин найм) төгрөгийн үнэ бүхий 8 цэцэрлэгийн барилга байгууламжийг хавсралтад дурдсаны дагуу нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.	НӨХГ-ын 2025.04.30-ны өдрийн 1/696 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас захирамжийн төсөлд саналын хуудас авхаар албан бичиг илгээж санал авч байна.	70%

14.	Барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авах тухай 2025.04.15, дугаар 25/66	1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянгол, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт тус тус баригдаж, ашиглалтад орсон нийт 4,219,867,853.00 (дөрвөн тэрбум хоёр зуун арван есөн сая найман зуун жаран долоон мянга найман зуун тавин гурав) төгрөгийн өртөг бүхий хавсралтад дурдсан "Хороо, өрхийн эрүүл мэндийн төв, цагдаагийн хэсгийн цогцолбор"-ын 2 барилга, байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.	НӨХГ-ын 2025.04.30-ны өдрийн 1/694 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас захирамжийн төсөлд саналын хуудас авхаар албан бичиг илгээж санал авч байна.	70%
15.	Барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авах тухай 2025.04.15, дугаар 25/67	1.Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт тус тус баригдаж, ашиглалтад орсон нийт 5,308,487, 144.00 (таван тэрбум гурван зуун найман сая дөрвөн зуун наян долоон мянга нэг зуун дөчин дөрөв) төгрөгийн үнэ бүхий "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын автобус паркийн угаах цех, кузов засварын барилга байгууламж, Сүхбаатар дүүргийн 17 дугаар хорооны "Хороо, өрхийн эрүүл мэндийн төв, цагдаагийн хэсгийн цогцолбор" барилгыг хавсралтад дурдсаны дагуу нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.	НӨХГ-ын 2025.04.30-ны өдрийн 1/694 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас захирамжийн төсөлд саналын хуудас авхаар албан бичиг илгээж санал авч байна.	70%
16.	Бизнес инкубатор, үйлдвэр сургалтын төвийн барилга, байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авах тухай 2025.04.15, дугаар 25/68	1.Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон нийт 4,631,748,621.00 (дөрвөн тэрбум зургаан зуун гучин нэгэн сая долоон зуун дөчин найман мянга зургаан зуун хорин нэг) төгрөгийн өртөг бүхий "Эмээлт эко аж үйлдвэрийн парк" ХК-ийн "Бизнес инкубатор, үйлдвэр сургалтын төв"-ийн барилга байгууламжийг хавсралтад дурдсаны дагуу нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.	Нийслэлийн өмчийн харилцааны газрын 1/757 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас захирамжийн төсөлд саналын хуудас авхаар албан бичиг илгээж санал авч байна.	70%
17.	Орон сууцны 18 байрыг нийслэлийн өмчид бүртгэн авах тухай 2025.04.15, дугаар 25/69	1."Нийслэлийн Орон сууцны корпораци" ХК-ийн "Дорнын Их гэгээ" ХХК-тай байгуулсан "Орлогд нийцсэн орон сууцны төсөл хамтран хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын гэрээ"-ний дагуу Хан-Уул дүүргийн 25 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон, нийт 1,786, 176,000.00 (нэг тэрбум долоон зуун наян зургаан сая нэг зуун далан зургаан мянга) төгрөгийн өртөг бүхий хавсралтад дурдсан орон сууцны 18 байрыг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.	Нийслэлийн өмчийн харилцааны газрын 1/758 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас захирамжийн төсөлд саналын хуудас авхаар албан бичиг илгээж санал авч байна.	70%

18.	Барилга балансаас баланст шилжүүлэх тухай 2025.04.15, дугаар 25/71	1.Баянгол дүүргийн 10 дугаар хорооны “Ариун чанар” өрхийн эрүүл мэндийн төвийн баланст бүртгэлтэй, нийт 28,382,780.00 (хорин найман сая гурван зуун наян хоёр мянга долоон зуун ная) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хуучин өрхийн эрүүл мэндийн төвийн барилгыг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт балансаас баланст шилжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.	НӨХГ-ын 2025.04.30-ны өдрийн 1/692 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас захирамжийн төсөлд саналын хуудас авхаар албан бичиг илгээж санал авч байна.	70%
19.	Барилга балансаас баланст шилжүүлэх тухай 2025.04.15, дугаар 25/72	1.Налайх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах дүүргийн Цагдаагийн хэлтсийн баланст бүртгэлтэй, нийт 1,500,000.00 (нэг сая таван зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий цагдаагийн хэсгийн байцаагчийн өрөөний зориулалттай баригдсан хуучин барилгыг Нийслэлийн ерөнхий боловсролын 109 дүгээр сургуульд балансаас баланст шилжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.	НӨХГ-ын 2025.04.29-ны өдрийн 1/679 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас захирамжийн төсөлд саналын хуудас авхаар албан бичиг илгээж санал авч байна.	70%
20.	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн ээлжит III хуралдааны тэмдэглэлд: ХЭЛЭЛЦСЭН нь: Удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх тухай 2025.04.15, дугаар 07	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны ээлжит III хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцсэн бөгөөд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Д.Амгалан)-т ҮҮРЭГ БОЛГОХ нь: 1.Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд томилогдон ажиллаж буй хараат бус гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон эсэх талаарх одоогийн нөхцөл байдлыг тодорхойлох, шаардлагатай бол холбогдох хууль, журмын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, шинээр шалгарсан хараат бус гишүүдийг дэгийн дагуу Хуралд танилцуулах. Хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг үүрэг болгов. гэжээ.	НИТХ-ын 2025.02.26-ны өдрийн 25/33 тогтоол, шийдвэрийн дагуу Удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, шинээр томилох гишүүдийн урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. ТУЗ-ын болон Удирдах зөвлөлийн тогтоол, шийдвэрийг НӨХГ-ын 1/450, 1/442, 1/443 1/444 1/445 1/446 1/447 1/448 тоот албан бичгээр ОНӨААТҮГ-т болон ХХК, ХК-д тус тус хүргүүлсэн.	100%

ДАРГА  В.ОЮУМАА

ХЯНАСАН:ЗУХ-ИЙН ДАРГА

Т. ОЮУНТУУЛ

НЭГТГЭСЭН: ЗУХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

 М. ЭНХБАЯР